



# Starlink GEN2 төхөөрөмжийг Starlink.com сайтад бүртгүүлж үйлчилгээ идэвхжүүлэх заавар


1. Starlink.com сайт руу ороод баруун дээр байрлах 3 зураас("Бургер", Старлинкийн хүн нь өөрөө тэгж нэрлэдэг гэсэн) -> "SIGN IN" дээр дарна.





2. "Activate Your Starlink" дээр дарж Старлинк төхөөрөмжөө идэвхжүүлэх.



3. Төхөөрөмжийн хайрцаг дээрх иж бүрдлийн дугаарыг оруулна(KIT\*\*\*\*\*). Шинэ хэрэглэгч бол NEW ACCOUNT-г дарна. Хуучин хэрэглэгч бол EXISTING ACCOUNT-г дарна.



4. Монгол оронд хамаарах дурын нэг байршлаа(Суурин буюу Нэг байршилд ашиглах багц сонгох бол ашиглах газраа сонгоно) "Google Map" ашиглан оруулах ба тухайн цэгийн мэдээллүүдээс **нэрийг**, эсвэл доорх **кодыг ХУУЛЖ** оруулан **СОНГООД SEARCH** товчлуурыг дарж Монголд идэвхжих боломжтой үйлчилгээнүүдээс сонгоно.



5. a) ХӨДӨЛГӨӨНТ / ROAM багц

**250.000** төгрөгийн төлбөртэй үйлчилгээг сонгох бол энэ багцийг сонгоно.  
Таны сонгосон ХӨДӨЛГӨӨНТ/ ROAM багц нь 3 үйлчилгээний сонголт байна.



Үүнд:

- **МОБАЙЛ БҮС НУТГИЙН/MOBILE REGIONAL**: Тухайн бүртгүүлсэн хаягийн харгалзах тивийн аль ч цэгт ашиглах боломжтой.
- **МОБАЙЛ ГЛОБАЛ/ MOBILE GLOBAL** : Дэлхийн хаана ч ашиглах боломжтой.
- **МОБАЙЛ ПРИОРИТИ/ MOBILE PRIORITY**: Сүлжээний ачааллаас үл хамаарч СТАНДАРТ болон МОБАЙЛ багцнаас давуу эрхтэйгээр тухайн дата хэмжээ хүртэл хурдаа хадгалах боломжтой. Өндөр хэрэглээтэй байгууллагын хэрэгцээнд тохиромжтой.


**6) СУУРИН / RESIDENTIAL багц**

**210.000** төгрөгийн төлбөртэй үйлчилгээг сонгох бол энэ багцийг сонгоно.


Starlink.com сайт дээр 210.000 төгрөгийн төлбөртэй багцаас 250.000 төгрөгийн төлбөртэй багц руу шилжихэд буюу **багц ахиулахад** идэвхэжсэн байгаа үйлчилгээгээ заавал дуусгаж байж(1 сараар идэвхжүүлсэн бол тухайн сараа дуустал) шинэ багц идэвхжүүлэх боломжтой болно. Харин **багц бууруулах** эсвэл өөр **бүртгэл рүү шилжүүлэх** бол тухайн багцыг идэвхжүүлснээс хойш **90 хоногийн** дараа бууруулж шинэ багц идэвхжүүлэх эсвэл шилжүүлэх эрх үүснэ.



6. Холбоо барих мэдээллээ бөглөнө.



7. ACCOUNT ADDRESS буюу хэрэглэгчийн хаягийн мэдээллийг оруулна. <https://zipcode.mn/zipcodeMap> сайтаас шуудангийн zipкодоо харж болно. (Жишээ нь 14200) UPDATE ACCOUNT ADDRESS товчлуурыг дарж бүртгэлийн хэсгийг дуусгана.



8. BILLING INFORMATION -д олон улсын гүйлгээний эрхтэй VISA, MASTER, AMEX картны нэр, дугаар, дуусах хугацаа, CVV 3 оронтой кодыг алдаагүй оруулна. Картын дансны үлдэгдэл хангалттай байх ёстой. VAT талбар дээр байгууллагын регистр дугаараа оруулж өгч болно. Худалдаа хөгжлийн банкны виртуал карт, Голomt, Хас банкны "VISA" карт ашиглахыг зөвлөж байна. Зарим банкны карт давхар код илгээж баталгаажуулдаг.

Billing Information

13336

VISA

VAT (OPTIONAL)

VAT (OPTIONAL)

Service MNT250,000.00/mo

**DUE TODAY MNT250,000.00**

PLACE ORDER

ГОЛОМТ БАНК

### Added Protection

Please enter your E-PIN (E-Code) in the field below to confirm your identity for this purchase. This information is not shared with the merchant.

The E-PIN will expire within 4:45 minutes for security reason.

Merchant: 3DSSTARLINKNET  
Amount: MNT 250000.00  
Date: 20240526 17:53:39  
Card: \*\*\*\* \* 2718

E-CODE:

SUBMIT [Exit](#)

Зарим банкны хувьд E-Code-ийг та банкны АПП-аасаа авах боломжтой байдаг.(Kart -> E-pin/code үүсгэх.)

9. Таны бүртгэл амжилттай дуусч нэвтрэх **Нууц Үгээ** оруулан баталгаажуулна. **Нэвтрэх нэр** нь таны бүртгүүлсэн и-мэйл хаяг болно. Бүртгэл болон төлбөр баталгаажсан мэйлүүдийг хүлээн авна.

# SET YOUR PASSWORD

Please enter your new password

Password

Password (Confirmation)

Set Password

# Starlink төхөөрөмжийг суурилуулах

## Тэнгэр саадгүй харах байрлал олох

Хиймэл дагуулуудтай тасралтгүй холбоотой байхын тулд таны Starlink төхөөрөмж ямарваа нэгэн халхлагдах зүйлгүй, задгай байрлалд байх ёстой. Дараах үндсэн санамжыг ашиглан тохиромжтой байрлал олоорой.

Үүнд :

- ① - Тагт эсвэл цонхны тавцан дээр суурилуулахгүй байх
- Ханатай хэт ойр суурилуулахгүй байх
- Халхлагдсан гадаа орчинд суурилуулахгүй байх
- Өөрийн байшин, байрнаас гадна өөр саад болж болохуйц зүйлийг харах. Жишээ нь хөрш айлын хашаан дахь өндөр мод, шон гэх мэт.
- Мод, модны мөчир, шон, дээвэр гэх мэт зүйлс нь холболтонд саад болдог ба холболт тасрахад хүргэнэ.
- Аль болох өндөрт суурилуулах тусам сигнал хаах саад багасна. Жишээ нь өндөр тавцан, шон, дээвэр дээр г.м.





① Зузаан үүлтэй байх нь хурд багасах болон холболт тасалдах шалтгаан нөхцөл болно.

Тэнгэр саадгүй харах байрлал олохын тулд

1. "Starlink" App-г татан суулгаж авна.
2. Хамгийн сайнаар сүлжээ хүлээн авах байрлалаа "Check for Obstructions" хэрэглүүрийг ашиглан олно.

**Check for Obstructions** хэрэглүүрийг ашиглах нь

- a. Starlink App-н нүүр хуудаснаас "Check for Obstructions" эсвэл "Obstructions" хэрэглүүрийг нээнэ.
- б. Дэлгэцэн дээр үзэгдэх Алхамуудыг даган хийж суурилуулах газартаа тэнгэр харахад саад байгаа үгүйг шалгуулна.
- в. Starlink-ийн ямар төхөөрөмж ашиглаж байгаагаа сонгоно.
- г. Гар утсаа яаг суурилуулахаар төлөвлөж буй **өндөр, байршил** дээр байрлуулсан байх ёстой.





3. Аль болох л сигнал сайн авахын тулд Төхөөрөмжийг боломжоор нь босоо байрлуулна.

Хэрэв тохирсон байрлал олдохгүй бол дээвэр, шон эсвэл хана гэх мэт аль болох өндөр газар суурилуулах. Нэмэлтээр бэхлэгээ болон дагах хэрэгслийг Starlink-ийн дэлгүүрээс худалдан авах боломжтой.



# Starlink төхөөрөмжийг суурилуулах

1. Starlink төхөөрөмжийг сууринд нь бэхлэн Router-ээ тогонд залгана.

- ① - Бүх **холболтуудаа бүрэн** эсэхийг шалгачаад тогонд холбох.
- Тогны хэлбэлзэлд **Router шатах** өндөр эрсдэлтэй тул тогтвортой тогны үүсгэвэр ашиглахыг зөвлөж байна.




① Аянга буусан тохиолдол байхгүй ч хэт их ширүүн аянга цахилгаантай бороотой үед тогноос салгаж унтраахыг зөвлөдөг.




Цагаан гэрэл : Тогонд холбогдсон  
Гэрэл асахгүй байвал : Тогонд холбогдоогүй

2. Төхөөрөмж нь автоматаар хиймэл дагуулаа хайн хөдөлнө. Энэ үед гараараа хүрч, оролдож болохгүй.


3. ① Тэнгэр цэлмэг эсвэл борооны зузаан үүлтэй байхаас хамаараад 10-30 минутын дараа төхөөрөмж нь Starlink-н хиймэл дагуулын сүлжээнд автоматаар холбогдох ба хамгийн оновчтой өнцгөөр өөрөө хазайна.



Эвхэгдсэн байдал



Автомат долгион хайлтын үе





Автоматаар хазайсан байдал (интернэтэд холбогдсон)

4. Ингээд та Интернетэд холбогдох боломжтой болсон байх ба Wifi хэсгээс STARLINK гэсэн нэртэйг олж холбогдоно. STARLINK App-г ашиглан тохиргоо өөрчлөх, холболтоо шалгах гэх мэт зүйлсийг харах, засах боломжтой.





# Starlink АПП

1. Starlink төхөөрөмжийг сууринд нэхлэн Router-ээ тогонд залгасны дараа АПП-аа нээн Email, Нууц үгээ ашиглан нэвтэрч(а) орно. "Start Setup"(б) дээр дарж төхөөрөмжөө сонгоно(в). Starlink төхөөрөмж нь гадаа, тэнгэр харахад саадгүй орчинд байх ёстой тул "Check for obstructions"(г) хэрэглүүрээр суурьлуулах орчинд нь саад байгаа үгүйг шалгаж болно. Тэнгэр саадгүй харж байгаа гэж үзэж байгаа бол "I have a clear view"(д) гэсэн дээр дарна.

① Хэрэв та Satcomm-оос санал болгож буй **40GB Priority +** багцийн хэрэглэгч бол АПП дээр нэвтэрч орох шаардлагагүй.



2. Router-ээ тогонд холбосон бол "My Starlink is plugged in"(а) дээр дарна. Router ассан л бол автоматаар "STARLINK"(б) гэсэн нэртэй WIFI цацаж эхлэх ба(1-3мин дотор) АПП-аасаа "Open Settings"(в) дээр дарж STARLINK нэртэйд(г) холбогдоно.



- Ⓐ Дахин ачааллах
- Ⓑ Үйлдвэрийн тохиргоо руу оруулах
- Ⓒ Wifi-н нэр, нууц үг солих
- Ⓓ Антен дээрх цасыг хайлуулах
- Ⓔ Амраах горим тохируулах
- Ⓕ Төхөөрөмжийг эвхэх, дэлгэх

Ⓖ Төхөөрөмжөө зөөхөөр бол унтраахаасаа өмнө эвхэхээ мартуузай.

- ← Wifi-даа нэр, нууц үг оруулах
- ← Үндсэн үзүүлэлтүүд, статистик
- ← Wifi-д холбогдсон төхөөрөмжүүд
- ← Антены бартаа, саадыг шалгах
- ← Интернэт хурд шалгах

① **40GB Priority +** багцийн хэрэглэгч бол Wifi-н нэр, нууц үг солихдоо Саткомм-ын 72720055 дугаарт мэдэгдэж солиулна.

